

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн есдүгээр хавсралт

**МОНГОЛ УЛСАД САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРААР ДАМЖУУЛАН  
ДААТГАЛЫН БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ГАДААДЫН ДААТГАГЧ, ГАДААДЫН ДААТГАЛЫН  
МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИД ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Гадаадын даатгалын компани (цаашид “гадаадын даатгагч” гэх) болон гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч компани (цаашид “гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч” гэх) Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраар дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулахад тавигдах шаардлага, түүнтэй холбоотой үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

**Хоёр.Гадаадын даатгагч, гадаадын мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газарт тавигдах шаардлага**

2.1.Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газар нь дараах шаардлагыг хангаж ажиллана:

2.1.1.Компанийн тухай хуулийн 7.5 дахь хэсэгт заасны дагуу бүртгүүлсэн байх;

2.1.2.Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн хувьд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл тогтоодог байгууллагаас тогтоосон зэрэглэлтэй байх;

2.1.3.Монгол Улсын аль нэг банкны дансанд даатгалын баталгаа хөрөнгө байршуулсан байх ба энэхүү хөрөнгийн доод хэмжээ нь гадаадын даатгагчийн хувьд 1 тэрбум төгрөг, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн хувьд 500.0 сая төгрөг байх шаардлагыг хангасан байх;

2.1.4.Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг зохицуулсан, хууль тогтоомжид нийцсэн журамтай байх;

2.1.5.Өөрийн харьяалагдах болон Монгол улсаас бусад улс оронд даатгалын салбар, төлөөлөгчийн газар байгуулж, уг салбар, төлөөлөгчийн газар тухайн нутаг дэвсгэртээ 2-оос доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;

2.1.6.Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх хүсэлт гаргагч гадаадын даатгагчийн өөрийн хөрөнгө нь 10 тэрбум төгрөгөөс багагүй, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн өөрийн хөрөнгө нь 1 тэрбум төгрөгөөс багагүй байх;

2.1.7.Харьяалагдах орны болон бусад улс орны Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомж, түүнтэй холбоотой бусад хууль, журмыг сүүлийн 2 жилийн хугацаанд зөрчөөгүй, уг зөрчлөөс үүдэн нэгжийн зөвшөөрөл хүчингүй болж, төлбөрийн чадварын болон санхүүгийн хүндрэлд орж байгаагүй;

2.1.8.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд оролцож байгаагүй байх;

2.1.9.Монгол Улсын хууль тогтоомж, Хорооноос баталсан дүрэм, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулах чадвартай байх;

2.1.10.Даатгалын үйл ажиллагааны 3-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөөтэй байх. Гадаадын даатгагчийн хувьд даатгалын зах зээлд нийлүүлэх 1-ээс дээш бүтээгдэхүүнтэй байх;

2.1.11.Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг хэвийн явуулах ажлын байртай байх;

2.1.12.Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн салбар нь 4-өөс доошгүй, гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн төлөөлөгчийн газар нь 2-оос доошгүй орон тооны ажилтантай байх;

2.1.13.Энэ журмын 2.1.12-т заасан ажилтнуудын 50-аас доошгүй хувийг Монгол Улсын иргэдээс бүрдүүлсэн байх;

2.1.14.Даатгалын тухай хуулийн 20.10 дахь хэсгийг үндэслэн Хорооноос баталсан зааварт заасан тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан удирдах ажилтантай байх;

2.1.15.Гүйцэтгэх удирдлага нь гадаадын иргэн байх тохиолдолд монгол хэлээр ярьж, бичдэг байх, эсхүл орон тооны орчуулагчтай байх;

2.1.16.Гадаадын даатгагчийн салбар нь ердийн даатгал, урт хугацааны даатгалын алийг эрхлэх, гадаадын даатгалын зуучлагчийн салбар нь давхар даатгал, ердийн даатгал, урт хугацааны даатгалын гэрээний алинд зуучлах талаар чиглэлээ тус тус тодорхойлсон байх;

2.1.17.Хороо гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газрын эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэрээс хамааран шаардлагатай гэж үзсэн нэмэлт нөхцөл, шаардлага тавьж болно;

2.1.18.Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн салбар нь гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн оноосон нэрийн ард “.....даатгалын салбар” гэсэн нэртэйгээр үйл ажиллагаа явуулна;

2.1.19.Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн төлөөлөгчийн газар нь гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн оноосон нэрийн ард “.....даатгалын төлөөлөгчийн газар” гэсэн нэртэйгээр үйл ажиллагаа явуулна.

2.3.Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч нь энэ журмын 2.1.3-т заасан даатгалын баталгаа хөрөнгийг Монгол Улсын нутаг дэвсгэрт буй аль нэг банканд байршуулах, эсхүл Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны бонд хэлбэрээр байршуулна.

--oo0oo--